



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/538

Булган сум

Теле камерын хяналтын дэд төвийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны хуралдааны VII/38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Теле камерын хяналтын дэд төвийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажилд 4,500,000 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөг зарцуулсугай.

2. Теле камерын хяналтын дэд төвийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зардлыг “Цахим Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

3. Үнийн саналыг авч, шууд худалдан авалт хийж тайланг ирүүлэхийг Теле камерын хяналтын дэд төвийн дарга (Г.Насантогтох)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР